БАТЛАВ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 02 дугаар сарын 02 өдөр

"ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын нэр: Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн ХТП-229 дэд өртөөнөөс шинээр 10 кВ-ын кабель шугам, 250кВА чадалтай КТПН дэд өртөө барьж 0.4 кВ-ын цахилгаан түгээх агаарын шугам татан ачаалал хуваах.

Байршил: Өмнөговь аймаг Даланзадгад сум

Ажлын зорилго: Даланзадгад сумын Нисэх хорооллын зүүн хэсгийг цахилгаан эрчим хүчээр хангадаг 10/0.4 кВ КТПН-192, ХТП-223 дэд өртөөнүүдийн, 0.4 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын ачааллыг хувааж шинээр 10/0.4кВ-н 250 кВА чадалтай дэд өртөө, 0.4 кВ-ийн цахилгаан түгээх агаарын шугам барьж ачааллаас шалтгаалсан тасралтын тоо хэмжээг бууруулах, хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах

Ажлын технологийн үндсэн шаардлага: Цахилгаан тоноглолын угсралтын ажлыг цахилгаан байгууламжийн норм ба дүрэм /ЦБД/, стандартыг баримтлан технологийн дагуу, чанартай сайн хийж гүйцэтгэх.

Дараах нөхцөлүүдийг нийлүүлэгч анхаарч ажиллана:

- Одоо байгаа Даланзадгад сумын 10/0.4кВ ХТП-229, КТПН-192 дэд өртөөний 0.4 кВ-ын ЦДАШ-тай газар дээр нь танилцах.
- 0.4 кВ-ын ЦДАШ-н шинээр татсан СИП кабельд одоо байгаа хэрэглэгчдийг фазын ачааллыг тэнцүүлж холболт хийх.
- ЦДАШ-н угсралтын ажлын зураг, ажлын акт болон гүйцэтгэлийн бичиг баримтын эх хувийг "ӨБЦТС" ТӨХК-нд хүлээлгэн өгөх.
- Угсралтын бүх тоноглол 2025 оноос хойш үйлдвэрлэгдсэн шинэ байх

Ажлын даалгавар:

- 10 кВ РП-2 хаалттай хуваарилах байгууламжийн салбар 10/0.4 ХТП-229 дэд өртөөний 10 кВ ячейкаас кабель шугамаар гаргалгаа гаргаж 10 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамыг үргэлжлүүлэн татаж шинээр 10/0.4 кВ-ын 250 кВА чадалтай иж бүрэн КТПН дэд өртөө шинээр барих.
- 10 кВ гаргалгааны кабель шугам, 10/0.4 кВ КТПН дэд өртөөний оролтын кабель шугамуудад хуурай салгуур угсарсан байна.
- Дэд өртөөний гадуур хамгаалалтын торон хашаа хийх.

- Шинээр угсарсан дэд өртөөний трансформаторын хүчин чадалтай уялдуулж 10 кВ-ын гал хамгаалагч, Орос улсад үйлдвэрлэсэн РВО маркийн 10 кВ-ын цэнэг шавхагч суурилуулах.
- Дэд өртөөнд 0,4кВ ерөнхий 800А рубильник, 630А автомат, гаргалгаа нь дээр 400А 4 ширхэг, 250 А 2 ширхэг автоматуудыг тус тус монтажлах.
- Шинэ дэд өртөөний 0.4 кВ щит хайрцагт 600/5 гүйдлийн трансформатор, 5А тоолуур /DTSD545S/ сонгох ба "ӨБЦТС" ТӨХК-ийн ухаалаг тоолуурын системд бүрэн нийцэж ажилладаг тоолуур суурилуулах ба олон улсын DLMS протокол дэмждэг, тухайн 0.4 кВ-ын дэд өртөөний мэдээлэл цуглуулах дата концентратортой PLC буюу хүчдэлийн шугамаар холбогдож мэдээллээ илгээдэг байх. Мөн GSM сүлжээгээр мэдээлэл дамжуулах сим картын ороллтой байх. RS485, оптик холболтоор холбогдон тохиргоо, үзлэг үйлчилгээ хийх боломжтой байх.
- Дэд өртөөнд мэдээлэл цуглуулж, дамжуулах дата концентратор: Хэрэглэгчдийн ухаалаг тоолуураас шаардлагатай параметрүүдийг ямар нэгэн нэмэлт холболтын кабель шаардахгүй, PLC /power line carrier/ буюу хүчдэлийн шугамаар дамжуулан авч байдаг төхөөрөмж бөгөөд 0.4 кВ-ын хүчдэлийн түвшинтэй дэд станцын толгой тоолуурын хамт байрлана. Дата концентратор нь үүрэн холбооны GSM сүлжээний 3G/4G хурдаар мэдээллийг "Ухаалаг тоолуурын төв сервер"-т илгээх ба нэмэлт антентай байна
- Шинэ дэд өртөөний 0.4 кВ-ын щит хайрцгаас 4 ширхэг 3х120+1х70 кабель шугамаар гаргалгаа гаргаж одоо байгаа 10/0.4 кВ ХТП-223, КТПН-192 дэд өртөөний 0.4 кВ гаргалгааны төгсгөлийн 8 салбар шугам тэжээх.
- 0.4 кВ гаргалгааны үндсэн шугамыг СИП-2А 3х70+1х70 шугамаар тэжээх ба нэмэлтээр УКШ-9.27.15 маркийн төмөр бетон тулгуур босгох.

Ажлыг хүлээн авах:

- Захиалагч байгууллагаас ажлын даалгаврын дагуу хяналтыг үе шат бүрт хийнэ.

- Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс шаардлагууд болон даалгаварын дагуу хянаж шалган акт үйлдэж хүлээн авна.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.ГАНТӨМӨР

БОЛОВСРУУЛСАН:

ЦШСҮЛЖЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА: М.БАНЗРАГЧ